

ГЛОБАЛЧЛАЛ АЗИЙНХАНЫГ ХӨДӨЛГӨӨНД ОРУУЛЖ ЭХЭЛЛЭЭ

Ц.Баатар*

Өнөөгийн эринийг дэлхий нийтээрээ Азийн эрин үе хэмээн хүлээн зөвшөөрөөд удсан хэдий ч нийт Азийнхан маань нэг л хөдөлж өгөхгүй тэрүүхэндээ эргэлдэж байсныг глобалчлал хэмээх хурдасгагч хөдөлгүүр хөдөлгөөнд түлхэн оруулав бололтой. Нийт Азийн хэмжээнд нэгдмэл байгууллага бий болгож хамтаараа асуудлыг шийдвэрлэх туршлага хараахан хуримтлуулж чадаагүй байгаа Ази тив глобалчлалын түрэлтээр эвсэн нэгдэж, харилцан хамааралд орж, бие биенээ дэмжин дэлхийн нэгдсэн сүлжээнд нэгэн хүч болон оролцох нь өнөөдөр юу юунаас чухал болоод байгааг Азийнхан ухаарч эхэллээ. Европ, Хойд Америктай зүйрлэх нь бүү хэл Африкийн орнуудын түвшинд хүрсэн хамтын ажиллагааны механизмыг ч бүрдүүлж чадаагүй байгаа Азийн бүс нутагт өнөөгийн нөхцөлд хэрэгжиж байгаа хамтын ажиллагаа нь газар зүйн байрлалд тулгуурласан, хоёр талын болон дэд бүсийн уламжлалт хамтын ажиллагааны сувагт л гол төлөв түшиглэж ирэв. Азид оршин буй орон бүрийн ашиг сонирхолыг илэрхийлсэн, тэдний хүчийг нэгтгэн зангидаж, уялдуулан зохицуулсан олон талын хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлэх санал, санаачилга хэдэн жилийн өмнөөс гарч, олон удаа хэлэлцэгдэж ирсэн хэдий боловч төдийлэн нааштай ахиц гаралгүй өнөөг хүрсэн билээ. Үүнд олон хүчин зүйл нөлөөлж байсан нь мэдээж.

Ази нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн макро үзүүлэлтээрээ асар их далд хүчин чадлыг агуулж буй атлаа тэрхүү хүчин чадлын хэмжээнд дүйлхүүц дотоод сүлжээг өнөө хэр зохион байгуулж амжаагүй явна. Азийнханд өнөөдөр ийм сүлжээ бий болгож, түүнийгээ дэлхий дахины хэмжээний сүлжээнд нэгтгэх асуудал цаг үеийн шаардлагаар хурцаар тавигдаж байгаа билээ. Энэ сүлжээний эх суурийг бий болгоход гол үүрэг гүйцэтгэж чадах зохион байгуулалтын бүтцийг бий болгохын тулд Азийн улсууд ихээхэн хүчин чармайлт тавьж эхэллээ. Үүний нэгэн тодорхой жишээ гэвэл 2002 онд Тайландын ерөнхий сайд Таксин Шинаватра (Thaksin Shinawatra)-гийн санаачлагаар эх суурь нь тавигдсан “Азийн хамтын ажиллагааны яриа хэлцээ” (Asian Cooperation Dialogue) /ACD/ хэмээх албан бус, зохион байгуулалтын бүтцэд ороогүй байгууллагыг нийт Азийн орнуудыг хамруулах зорилгоор байгуулсан билээ. Гол зохицуулагч нь Тайланд. Байгуулагдаад удаагүй боловч эдүгээ Азийн өнцөг булан бүрийн төлөөллийг багтаасан 28 орон гишүүнээр элсээд байна. Гол яриа хэлцээ, уулзалт нь гишүүн

*Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

орнуудын Гадаад хэргийн сайд нарын хэмжээнд болдог аж. Жил бүр гишүүн орнуудын Гадаад хэргийн сайд нар уулзаж тулгамдсан асуудлаа харилцан солилцдог уламжлал тогтоод 4 жил болж байна. Уулзалтын хажуугаар гишүүн орнуудын хүрээнд хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэх, эрдэмтэд шинжээчдийн симпозиум зохион байгуулах, АСD-ийн хүрээнд Think Tank-ийн уулзалт хийж зөвлөмж гаргах зэрэг өргөн цар хүрээтэй, олон төрлийн арга хэмжээг гишүүн орнуудын санаачлагаар жилд хэд ч хамаагүй зохион байгуулдаг аж. Өнгөрсөн хугацаанд гишүүн орнуудын санаачлагаар зөвхөн нэг төрлийн арга хэмжээг 3-4 удаа зохион явуулсан байх жишээтэй.

АСD-ийн гишүүн орнуудын Гадаад хэргийн сайд нарын ээлжит 4 дэх удаагийн уулзалт, эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлаархи шинжээчдийн зөвлөлдөх семинар 2005 оны дөрөвдүгээр сарын 5-7-нд Исламын Бүгд Найрамдах Пакистан Улсын нийслэл Исламабад хотноо боллоо. Гишүүн орон бүр АСD-д ихээхэн чухал ач холбогдол өгч төрийн түшээд болон судлаачдаа аль болох өргөн оролцуулдаг нь энэхүү уулзалт, семинараас тодорхой харагдаж байлаа. Гишүүн орон бүрээс 3-5 судлаач оролцсон нь үүнийг гэрчилнэ.

Энэ удаагийн хуралдаанд манай улсаас Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил, Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын орлогч захирал П.Гансүх нар сайд нарын уулзалтад, шинжээчдийн зөвлөлдөх семинарт миний бие “Азийн регионализм ба Монгол Улс” гэсэн илтгэл тавьж оролцлоо.

Уулзалт, семинарын үр дүнд Исламабадын Тунхаглал, Азийн эдийн засаг, хамтын ажиллагааны Исламабадын санаачлага гэсэн хоёр баримт бичиг гаргалаа. Дээрхи баримт бичгийн агуулга болон улс төрчид, шинжээчдийн байр суурийг тоймлон олон нийтэд хүргэх нь Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйлсийг зөв тодорхойлох, Азийн хамтын ажиллагааны хөгжлийн өнөөгийн чиг хандлагын талаар баримжаа авах зэрэг боломж олгоно гэдэгт найдна. Дашрамд өгүүлэхэд дээрх үйл явцын ач холбогдлыг харгалзан энэ тухай тойм мэдээллийг өргөн олонд цаг хугацаа алдалгүй хүргэх үүднээс манай өдөр тутмын том сонины нэг болох “Өдрийн сонин”-д тухайн үед хандсан боловч тэд түүнд ямар ч ач холбогдол өгсөнгүй. Хэмжээ том, түүнээс илүү “чухал” материалд дарагдаад байгаа гэсэн “сайхан” хариу сонссон юм. Одоо эргээд үндсэн сэдэвтээ оръёо.

Судлаачид, шинжээчид орон бүхэн, түүний дотор Азийн улсууд Азийн эрин үеийн тухай номлолыг бодит ажил хэрэг болгохын тулд хамтран ажиллах шаардлага хэзээ хэзээнээс чухал болоод байгааг нэгэн дуугаар хүлээн зөвшөөрч, Азийн улс төрийн орчны дулаарлаас үйл явцын өрнөлт хоцорч байна гэдэгт санал нэгтэй байлаа.

Улам бүр ил тод, нээлттэй, харилцан хамааралтай болж буй олон улсын өнөөгийн нийгмийн амьдралд глобалчлалын үйл явц улам эрч хүчтэй түрэн орж ирж байгааг ч хүлээн тэд хүлээн зөвшөөрч байв. Энэ нөхцөлд Азийн орнууд өөрсдөө глобалчлалын ашиг тусыг хүртэхийн тулд байр сууриа зөв тодорхойлон, харилцан ашигтай харилцаа холбоо тогтоон, зүй зохистой харилцан хамаарлыг төлөвшүүлэх, өөр хоорондын эдийн засгийн эрх тэгш бус ялгавартай байдлыг арилгахын чухлыг онцлон тэмдэглэж байв. Эрх тэгш бус байдал нь тогтворгүй байдлын уг шалтгаан болж, үүнээс үүдэн хэт даврах үзэл гарч ирж байна. Тийм учраас Азийн аугаа их өв уламжлал, соёл иргэншлийн мартагдсан хэлхээ холбоог сэргээн тогтоохын чухлыг ч нэгэн дугаар талархан дэмжиж байлаа.

Тунхаглалд Ази бол соёл, оюун ухаан, авьяас чадварын ихээхэн нөөц баялагтай тив. XXI зууны эхний арван жилийн хугацаанд Ази тив энх тайван, хөгжил дэвшлийн төлөөх түншлэлийг бий болгосноороо дэлхийн тавцан дээр гялалзсан шинэ од болон гарч ирэх боломж бүрдлээ. Дэлхийн улс түмний нэгэн адил Ази тивийн хүн ардын хувь заяа хоорондоо салшгүй уялдаа холбоотойг хүлээн зөвшөөрөх ёстой. Ази бол асар их нөөц баялагтай аугаа том тив мөн. Бид Азийнхаа баялаг соёл иргэншлийг төлөвшүүлэн, Ази тив болон даян дэлхийн энх тайван, ирээдүйн хөгжил цэцэглэлийг хангахын төлөөх нийтийн хүчин чармайлтад эдийн засгийн ололт амжилтуудаа зориулах ёстой. Улс төрийн ужиг маргаан, аливаа хямралыг энхийн замаар шийдвэрлэх шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч, энх тайвнаар зэрэгцэн орших чин үнэн сэтгэлээр бүх улс үндэстний уламжлал, үнэт зүйлс, улс төр, нийгмийн тогтолцоонд хүлээлтэй бөгөөд хүндэтгэлтэй хандах ёстой. Глобалчлал хэмээх содон үзэгдлийг дэлхийн бүс нутгууд ялангуяа, Азийн алс хязгаар салбар бүс нутгуудад асар их ашиг тустайгаар хандуулах, ингэснээр ядуурлыг бууруулан, хөгжиж буй орнуудад худалдааны илүү таатай нөхцөл, бололцоог бүрдүүлж, хүний сайн сайхны төлөө боловсронгуй технологио хуваалцан, байгаль орчноо хамгаалж, хэн бүхнийг ажлын аятай нөхцөл бололцоогоор хангах асуудлыг шийдвэрлэх нь чухал. Бүс нутагт эдийн засаг, худалдааг өргөнөөр хөгжүүлэх нь глобалчлалд дасан зохицох хамгийн үр нөлөөтэй арга хэрэгсэл. Ийм чиг хандлага олон үйл явцыг үзэж өнгөрүүлсэн Азийн бүс нутагт тод томруун харагдаж байна. Ази тивдээ энх тунх аж төрж, хөгжин цэцэглэх нь бидний зорилго бөгөөд бид үүний төлөө зорин тэмцэж, бодит үйл хэрэг болгох болно. Ингэхийн тулд юуны өмнө өргөнөөр хамтран ажиллах замаар Ази тивийн хөгжин дэвших нөхцлийг бүрдүүлэх ёстой. Иймд харилцан итгэлцэл, ойлголцол бий болгох нь юу юунаас ч чухал боллоо. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа, интеграцчлалыг урагшлуулахад дэд бүс нутгийн хамтын ажиллагааны

механизмууд, тухайлбал, Зүүн өмнөд Азийн улсуудын холбоо (ASEAN), ASEAN+3-ын хамтын ажиллагаа, Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (SCO), Бүс нутгийн хамтын ажиллагааны өмнөд Азийн холбоо (SAARS), Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (ECO), Бангладеш, Энэтхэг, Мьянма, Шри Ланк, Балба, Бутан болон Тайландын эдийн засгийн хамтын ажиллагаа (BIMSTEC), Харилцан ажиллагаа, итгэлцлийг бий болгох арга хэмжээний бага хурал (CICA), Персийн булангийн хамтын ажиллагааны Зөвлөл (GCC) зэрэг бүсийн байгууллагууд чухал хувь нэмэр оруулж байна. Энэ бүх хүчин чармайлтын үр дүнд хамтын ажиллагааны сүлжээг бүрдүүлэн, Азийн хүн ардын тусын тулд аугаа их Ази тивд сайн хөршийн харилцаа тогтоох, Ази тивийн хэмжээнд хамтран ажиллах баттай үндэс суурь нэгэнт бүрдсэн болохыг Тунхаглалд онцлон тэмдэглэжээ.

ACD нь бүх салбар бүс нутгийг холбох, хамтын ажиллагааны одоогийн хүрсэн түвшин, цар хүрээг тэлэх, төгөлдөржүүлэх замаар Азийн хүч нөөц, сүр хүч, олон янзын өнгө төрхийг бүрдүүлэх чухал сэжиг болохын хувьд зохистой үүрэг гүйцэтгэж байна. Энэхүү чуулга уулзалт нь Азийн орнууд өөрсдийн нааштай бодол сэтгэлгээний язгуур үнэт зүйлс, түгээмэл шинж чанар, өөдрөг сэтгэл, түүнчлэн, өргөжин тэлж, хувьсан өөрчлөгдөж буй албан ёсны биш үйл явц болохын хувьд ACD-д тулгуурлан яриа хэлцээ хийж, хамтран ажиллах үр нөлөөтэй үндэс суурийг бүрдүүлэхийн төлөө гишүүн орнууд хүчин чармайлтаа нэгтгэхийн чухлыг Тунхаглалд цохон тэмдэглэжээ.

ACD-ийн гишүүн орнуудын хүрээнд ядуурлыг бууруулах, санхүү, аялал жуулчлал, жижиг, дунд үйлдвэрлэл, биотехнологи, мэдээллийн технологи, эрчим хүч, e-боловсрол, хөдөө аж ахуй зэрэг салбарт төслийн хамтын ажиллагаа, түүнд нэгдэн орж буй орнуудын тоо өсөн нэмэгдэж, хууль эрх зүйн дэд бүтэц, байгаль орчны боловсролын жишиг тогтоох, автозамын аюулгүй байдлыг хангах зэрэг хамтын ажиллагааны төслүүдийн үйл ажиллагааны үр дүнд ихээхэн ахиц дэвшил гарч байгааг гишүүн орнуудын төлөөлөгчид сэтгэл ханамжтай тэмдэглэж байлаа. Шинжээчид хамтын ажиллагааны тулгамдсан олон асуудлаар чөлөөтэй санал солилцож нэгдсэн ойлголтод хүрснээр Исламабадын санаачлага хэмээх баримт бичиг гаргалаа.

Азийн эдийн засаг, хамтын ажиллагааны Исламабадын санаачлал: Азийн сайн хөршийн харилцааны номлолыг ACD-ийн үзэл санааны дагуу гишүүн орнууд цаашдаа дараах чиглэлд хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Юуны өмнө эрчим хүчний талаар харилцан хамтран ажиллах, тухайлбал аюул осолгүй, баталгаатай хангамжийг бий болгохын төлөө харилцан ашиг тустай хамтран ажиллах, түүнчилэн био хий, салхи,

нарны эрчим хүч зэрэг эрчим хүчний нөхөн сэргээгдэх эх үүсвэрийг хөгжүүлэн, нэвтрүүлэх талаар харилцан ажиллах;

- Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн технологи, аж үйлдвэрийн салбарт эрчимтэй хамтран ажиллах замаар хүнсний аюулгүй байдлыг хангах, энэ үүднээс АСD-ний Хөдөө аж ахуй болон Хөдөө аж ахуйд суурилсан аж үйлдвэрийн Зөвлөлийн үндэс суурийг тавих чигт зорин тэмүүлэх;

- Хоёр талын харилцаа, бүс нутгийн хийгээд дэлхий дахины чуулга уулзалтуудаар уламжлан, Азийн хэмжээний чөлөөт худалдааны зохион байгуулалтын бүтцийг бий болгох зорилтыг цаашдаа хэрэгжүүлэх үүднээс худалдааг чөлөөтэй болгохын төлөө ажиллана. Үүнтэй холбогдуулан АСD-ийн гишүүн орнуудын Худалдааны яамны сайд нарын уулзалтуудыг тогтмолжуулах;

- Хөрөнгө оруулалт, хамтарсан үйлдвэрүүдийг дэмжин, аливаа бололцоог зохистой ашиглахын тулд гишүүн орнууд өөр хоорондоо худалдааг хамтран хийхийг идэвхтэй хөхиүлэн дэмжих;

- АСD-ний гишүүн орнуудын Төв Банкуудын захирал нарын уулзалт хийх арга механизмыг ашиглаж, Азийн орнуудын эдийн засгийг хамгаалан, дэмжих зохистой нөхцөл бололцоог бий болгох үүднээс санхүү, мөнгөний бодлогын талаар АСD-ний гишүүн орнуудын дунд илүү сайн ойлголцолыг бий болгохын төлөө хүчин чармайлт гаргах;

- Валют санхүү, хөрөнгө оруулалтын хил дамнансан чөлөөт хөдөлгөөнийг хангахын тулд хөрөнгийн урсгалыг чөлөөтэй болгох, хэлбэлзлийг нь багасгах үүднээс хөрөнгийн зах зээл дээр хамтран ажиллаж, зөвлөлдөж байх талаар байнга санаачилгатай ажиллах. Үүний тулд АСD-ийн гишүүн орнуудын Хөрөнгийн биржүүд хоорондоо хамтран ажиллаж, зөвлөлдөж байх;

- Азийн үйлдвэрүүд бүс нутгийнхаа эдийн засгийн өсөлт, хөгжлийн тусын тулд өөрсдийн бүхий л хүч нөөцийг дайчлах, энэ үүднээс АСD-ийн гишүүн орнуудын Худалдаа, аж үйлдвэрийн танхимууд өөр хоорондоо нягт хамтран ажиллах явдлыг хөхиүлэн дэмжих;

- Азийн технологийн хүчин чадлыг бататгах, Азийн хэмжээнд мэдлэгт тулгуурласан нийгэмлэгүүдийг байгуулахын тулд АСD-ний гишүүн орнууд хамтран эрдэм шинжилгээ, судалгаа-туршилт боловсруулалтын ажил явуулахыг урамшуулан дэмжих;

- АСD-ийн гишүүн орнуудын хоорондох арилжаа наймаа, ардын дипломат бодлого, соёлын харилцаа, тэрчлэн аялал жуулчлалыг дэмжихийн тулд тээвэр, харилцаа холбооны үр нөлөө, ашиг тустай сүлжээг бий болгохын төлөө ажиллах;

- Дэд бүтцийг хөгжүүлэх, бараа, үйлчилгээ, мөн тээвэр, банкны салбарыг дэмжихийн тулд улсын болон хувийн салбарын хаана ч гэсэн

хоёр юмуу олон талын хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэхэд оролцох боломжийг хангах;

- Ази дахь эдийн засгийн хамтын ажиллагааны номлолоо бодит үйл хэрэг болгохын тулд АСD-ийн үйл явцыг цаашид ойртуулан жигдрүүлэх, өргөжүүлэн гүнзгийрүүлэх үүднээс АСD-ний гишүүн орнуудын дээд хэмжээний уулзалтыг хийх зэрэг өргөн цар хүрээтэй, чухал ач холбогдол бүхий санал санаачлага дэвшүүлээ.

АСD-ийн энэ удаагийн уулзалтаар Саудын Араб, ОХУ гишүүнээр элсч түүний гишүүн орнуудын тоо 28 болж өргөжлөө.

Уулзалт, семинарын явцаас ажиглаж байхад энэ чиглэлээр зохион явуулах үйл ажиллагааг гишүүн орон бүр аль болох өөрийнхөө оронд зохион байгуулах, хамтын ажиллагааны төсөлд оролцох тал дээр түлхүү, санаачлагатай оролцох хандлагатай байгаа нь харагдлаа. Гишүүн орнууд нийтдээ 19 төсөл санаачилснаас өдгөө 16 нь амжилттай хэрэгжиж байгаа тухай мэдээлж байв. Ажил хэрэгч хүмүүст хэрэг болох болов уу хэмээх үүднээс АСD-ийн гишүүн орнуудын хүрээнд хэрэгжүүлж буй төслүүдийг дараах хүснэгтээс үзнэ үү.

АСD-ийн гишүүн орнуудын санаачилсан хамтын ажиллагааны төслүүд

	Хамтын ажиллагааны төслүүд	Санаачлагч, хамтран санаачлагч орон
1.	Эрчим хүчний аюулгүй байдал	Бахрайн, Индонез, Казакстан, Катар, Хятад, Филиппин
2.	Ядуурлыг бууруулах	Бангладеш, Кампучи, Вьетнам
3.	Хөдөө аж ахуй	Хятад, Пакистан, Казакстан
4.	Тээвэр	Энэтхэг, Казакстан
5.	Биотехнологи	Энэтхэг
6.	Е-Худалдаа	Малайз
7.	Дэд бүтцийн сан	Малайз
8.	Е-боловсрол	Малайз
9.	Стандартын Азийн институт	Пакистан
10.	Жижиг дунд үйлдвэрийн хамтын ажиллагаа	Сингапур, Шри Ланк
11.	Мэдээллийн технологи	Өмнөд Солонгос
12.	Эрчим хүч	Филиппин
13.	Ш инжлэх ухаан, технологи	Филиппин
14.	Аялал жуулчлал	Тайланд, Кампучи, Мянмар, Пакистан
15.	Санхүүгийн хамтын ажиллагааны ажлын хэсэг	Тайланд
16.	Хүний нөөцийн хөгжил	Вьетнам
17.	Хүрээлэн буй байгаль орчны боловсрол	Япон, Катар
18.	Хууль эрх зүйн дэд бүтэц	Япон
19.	Автозамын аюулгүй байдал	Оман

Төслийг ямар улсууд санаачилсан, тухайн улс ямар асуудалд чухал ач холбогдол өгдөг болох зэрэг олон зүйлийг эндээс мөшгөн мэдэж болох биз ээ.

Дээрхи төслийн алинд ч манай улс хараахан оролцоогүй байна. Энэ нь бидэнд бас нэгэн зүйлийг хэлээд байгаа гэсэн үг. Дээрхи төслүүдэд АСД-ийн гишүүн орнууд хэр зэрэг ач холбогдол өгдөг болохын нэгэн илрэл нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 60 дугаар чуулганы хүрээнд Нью-Йорк хотноо саяхан болсон АСД-ийн гишүүн орнуудын Гадаад хэргийн сайд нарын ээлжит уулзалтаар дээрхи төслүүдээс хөдөө аж ахуйн салбарт биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчим хүчний аюулгүй байдал, зам, харилцаа холбоо, аялал жуулчлалыг хөгжүүлэх, гамшигийн менежмент зэрэг чиглэлээр хэрэгжүүлж буй төслүүдийн явц байдлыг онцгойлон авч үзэж хэлэлцсэн явдал юм. Уулзалтад оролцсон Монгол Улсын Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил хэлэлцэж буй асуудлууд, түүний дотор эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, ялангуяа нефть импортлогч жижиг эдийн засагтай орнуудад тулгарч буй бэрхшээлийг даван туулах чиглэлээр хамтран ажиллах, Азийн бүс нутагт санхүүгийн дэд бүтэц бий болгохдоо жижиг, дэд бүтэц сул хөгжсөн орнуудын чадавхийг нэмэгдүүлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлж ажиллахын чухлыг тэмдэглэсэн нь Монгол Улс дээрх төслүүдэд анхаарал хандуулж, ач холбогдол өгч эхэлж байгаагийн нэгэн илэрхийлэл гэж үзэж болох биз ээ.

Энэ бүхнээс үүдэн зарим санаа өгүүлье. Ядуурлыг бууруулахаас авахуулаад аялал жуулчлал, хөдөө аж ахуй, мэдээллийн технологи, авто зам, эрчим хүч, хүрээлэн буй байгаль орчны боловсрол, е-боловсрол, биотехнологи, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, бичил зээл, хөрөнгийн зах зээлийг зохицуулах, худалдааг чөлөөтэй хөгжүүлэх, Азийн нэгдсэн стандарт бий болгох зэрэг төсөл, хамтын ажиллагааны шинэ бүтцүүдийг бид анхааралдаа авч идэвхи гаргаж, түүнд зүүгдээд яваад байх, нэгдсэн сүлжээнд хамрагдах, зарим шинэ төслийн санаачлагч болж бусдыг араасаа дагуулах, Think Tank болон ер нь дээрхи чиглэлээр болж буй симпозиум болон аливаа уулзалт, семинарт салбар бүрээс судлаач, шинжээчдийг аль болох хамруулж идэвхи, санаачлагатай оролцох хэрэгтэй болов уу.

Уулзалт, семинар, өглөөний зоог, эрдэм шинжилгээний хурал гэх мэт янз бүрийн нэрийн дор зохиогдож буй дээрхи арга хэмжээнүүдийг санаачлагч улсын банк, санхүүгийн болон худалдаа аж үйлдвэрийн тэнхим, аялал жуулчлалын газрууд нь бүсийн санхүүгийн байгууллагуудтай хамтрах юм уу дангаараа зохион байгуулж иржээ. Үүнээс үзвэл эрдэмтэд саналаа солилцож, зөвлөмжөө боловсруулж, улс төрчид нь түүнийг хэлэлцэж шийдвэрээ гаргаж, бизнесийн хүрээнийхэн ашигтай бизнес сурталчилгаагаа

явуулж, гэрээ хэлэлцээр үзэглэж амждаг нь хэн хэндээ ашигтай үйл ажиллагааны шинэлэг хэлбэр ажиглагдаж байв.

Судлаачдын дүгнэлтэд үндэслэсэн шийдвэр хэрэгжих магадлал өндөр байдгаас сүүлийн үед иймэрхүү хэлбэр давамгайлах хандлагатай байна. Манайх шиг буурай хөгжилтэй, хараат эдийн засагтай, гадаад хүчин зүйл давамгайлдаг, Азийн салбар бүс нутгийн хамтын ажиллагааны ямар ч бүтцэд орж чадаагүй, хоцрох шахуу яваа орны хувьд иймэрхүү хэлбэр илүү зохистой үр дүнтэй байж болох талтай. Өөрөөр хэлбэл нэг сумаар хэд хэдэн туулай буудна гэсэн үг. Зардал ч ихээхэн хэмнэнэ. Аз таарвал зардал гаргахгүйгээр улсаа, бизнесменүүдээ аятайхан сурталчилаад авна.

Исламабадын семинарын завсар чөлөөгөөр бизнесийн хүрээнийхэн хамтын ажиллагаа санал болгосон, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, аялал жуулчлалыг өөртөө татах гэсэн танилцуулга, сурталчилгаа мэтийг ёстой нэг тараах шиг болж байна лээ.

Дээрхи байдлаас үзэхэд алив нэг олон улсын чанартай уулзалт, арга хэмжээг улс орондоо зохион байгуулахдаа цогц байдлаар хүчтэй, нэгдсэн зохион байгуулалтай, сүр дуулиантай хийх нь улс орноо дэлхийд биш юмаа гэхэд Азидаа сурталчилах, таниулах, мартсаныг нь сануулах томоохон боломж олгодог үр ашигтай арга хэрэгсэл болдог аж.

Пакистанд болсон энэ удаагийн хурал Азийн хөгжлийн банк, Исламын улсуудын банк, Хятад, Пакистаны төв банкуудын ивээл дор болж өнгөрөв. Эндээс өөрийн орондоо уулзалт зохион байгуулах эрх авч улс орноо рекламдаж чадсан Пакистан илүү их хожсон. Энэ бүхэнд Пакистаны талын лобби, овсгоо, хүчин чармайлт, нэр нөлөө, сүр хүч орсон нь мэдээж.

Манай төр засаг энэ мэт санаачлага гаргаж, бусдыг лоббидож АСД-ийн Гадаад хэргийн сайд нарын хэмжээний биш юмаа гэхэд Азийнханыг сэрээж доргиосон уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчдын чуулгантай ижил төстэй тийм олон улсын чанартай арга хэмжээ зохиох нь лавтай.

Учирлаваас манай засгийн газар эвсэж хамтын шийдвэр гаргах ур чадварын хувьд урд өмнө байгаагүй цорын ганц засгийн газар гэж байгаа. Тэгээд ч засгийн газрын тэргүүн маань энэ байтугай гайхамшигтай сайхан санаа байнга гаргаж, түмэн олноо гайхшруулж байдгийг бид мэдэх хойно.

Пакистан оронд зорчсон аян замын тэмдэглэлээ хэвлэлд нэгэнт нийтлүүлсэн тул энэ орны өсөлт хөгжлийн талаар энд тухайлан дурдсангүй.